

Өв залгамжлалын татварын онолын зарим асуудал

Some Theoretical Issues in Inheritance Tax Law

Баяр-Эрдэнийн Сарнай

Хууль зүйн ухааны магистр (LL.M).

Улаанбаатар хот, Монгол Улс

rozarosent@gmail.com



[Товч утга]

Иргэний баталгаатай эдлэх эрх, эрх чөлөө нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх юм. Иргэн үндсэн эрхийн хүрээнд өөрийн бий болгосон хөрөнгийг өв залгамжлуулахад өв хүлээн авагч, өв залгамжлуулагч нарын хооронд эдийн засгийн харилцаа бий болж байх тул үндсэн үүргийнхээ хүрээнд татвар төлөх ёстой гэж үздэг байна.

Энэ өв залгамжлалын албан татварыг Монгол Улсын албан татварын нэг төрөлд хамаарахаар зохицуулсан ч практикт хэрэгжихгүй, бэлгэдлийн шинжтэй зохицуулалт болсон байна. Энэхүү албан татварын нэг төрлийг өв залгамжлалын татварын эрх зүйн онолын үүднээс авч үзэхийг зорьсон бөгөөд судалгааны ажлын хүрээ өв залгамжлалын албан татварын эрх зүйн онолоор хязгаарлагдах болно.

[Түлхүүр үг]

Өв залгамжлал, эдийн засаг, өв хүлээн авагч, өвлөгч, үндсэн эрх, гэрээслэл, татвар.

I. Удиртгал

Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөний нэг хэсэг нь өв залгамжлах, өв залгамжлан авах эрх билээ. Энэ ч үүднээс өв залгамжлалын эрх зүйн асуудал бол эрх зүйн зохицуулалтын хүрээнд төдийгүй эдийн засгийн хүрээний маш өргөн агуулга бүхий харилцаа тул хувийн болон нийтийн эрх зүй асуудал юм. Манай улсын хувьд шүүхийн практикт өв залгамжлалын маргаан ихээр гарах болсон нь цаашид энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгаа болохыг харуулж байна.

Төр анх бий болсон тэр цагт татварын систем үүссэн гэж үздэг байна. Татварын системийн хөгжлийн эхэн үе эртний болон дундад зууны үе хамрагдах бөгөөд энэ үед татвар нь зохион байгуулалтгүй, санамсаргүй байдалтай байжээ. Татварыг бодит хэлбэрээр, ямар ч системгүй хурааж, таваар-мөнгөний харилцаа бэхжихийн хэрээр татвар нь мөнгөн хэлбэрт шилжиж эхэлсэн¹ түүхтэй.

Манай улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээр татварын систем шинээр бий болох эхлэл тавигдсан ч өөрийн орны татварын бодлогыг шинжлэх ухааны үүднээс боловсруулах, хамгийн үр ашигтай, шударга татвар хураах аргачлалыг бий болгох талаар эрэл хайгуул хийсээр байна.

Өв залгамжлалын албан татварын талаарх татварын эрх зүйн хэд хэдэн онол байх ба энэ онолын үзэл баримтлалыг судлах замаар өв залгамжлалын албан татвар ногдуулах, эсхүл ногдуулах нь буруу гэх асуултад хариулт өгөхийг зорьсон болно. Хэдийгээр Монгол улсад өв залгамжлалын албан татвар нь татварын нэг төрөлд хамаарахаар хуульчилсан боловч хэрэгжихгүй, бэлгэдлийн шинжтэй зохицуулалт болж байна. Гэхдээ өв залгамжлалын албан татвар хууль, эрх зүйн хүрээний асуудал болохоос гадна өв залгамжлалын албан татвар байх ёстой юу гэдгийг эдийн засгийн үзэл баримтлалын үүднээс авч үзэх шаардлага байх тул өв залгамжлалын эрх зүйн татварын онолын асуудлыг авч үзлээ. Энэхүү өгүүллээр өв залгамжлалын албан татварын эрх зүйн онолын үзэл баримтлалыг авч үзсэн буюу онолын чиг хандлагаар хязгаарлагдах болно.

Сэдвийн судлагдсан байдлын хувьд Т.Лхагважаргал “Монгол Улсын Үндсэн хууль дахь хуваарилалтын шударга ёс: өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар” бакалаврын зэрэг горилсон бүтээл, Н.Лхамцэрэн “Монгол Улсад өв залгамжлал ба бэлэглэлийн

¹ Ганхүлэг Б., Татварын тогтолцоо (Тэргүүн дэвтэр), (Улаанбаатар: 2002), 3 дахь тал.

албан татварыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага, түүний арга зам” эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэн байна. Энэ өгүүлэл нь бусад судлаачдын бүтээлээс өв залгамжлалын албан татварыг татварын эрх зүйн онолоор авч үзсэн гэдгээрээ шинэлэг болсон билээ.

Үндсэн хэсэг

Өв залгамжлалын харилцаа нь хууль зүйн болон эдийн засгийн шинжлэх ухаанд чухал байр суурийг эзэлдэг. Тодруулбал, өв залгамжлалын албан татвар нь эдийн засгийн шинжлэх ухаан талаасаа онцгой байр суурийг эзэлдэг байна. Татварыг зөвхөн төсвийн орлогын нэг хэсэг гэж үзэж болох ч онолын талаас нарийн төвөгтэй харилцаа юм. Өв залгамжлал, гэрээслэлийг үндсэн хоёр чиглэлээр хязгаарлаж болох ба үүнд 1) харилцааны хүрээгээр буюу өв залгамжлах эрхтэй этгээдийн төрөл садангийн хүрээг хумих /хязгаарлах/, 2) хэмжээгээр буюу нэг этгээд өөр нэг этгээдийн хөрөнгөөс өвлөн авах дээд хэмжээг тогтоох² гэсэн чиглэлээр хязгаарлах боломжтой. Энэ хязгаарлалттай дүйцэхүйц өөр нэг үндэслэл нь өв залгамжлалын албан татварын онол юм. Хоёрдогч өв залгамжлалыг хязгаарлах буюу өмчийг улсын өмчид шилжүүлэх хүрээ, хязгаарыг тэлэх, баялгийн хуваарилалтыг өргөн хүрээтэй болгох явдал юм.

Өв залгамжлалын албан татварыг татварын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзвэл, түүнийг дараах байдлаар авч үздэг. Үүнд: 1) хураамж-төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө, 2) татвар- аливаа этгээдийн орлого, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт байгаа мөнгөн хөрөнгө юм. Өв залгамжлалын албан татвар нь төрийн үйлчилгээ үзүүлсний төлбөр, өв залгамжлал, гэрээслэл үйлдэхэд үзүүлэх үйлчилгээний төлбөр, өв залгамжлалын маргааныг шийдвэрлэхэд гарах шүүхийн зардал зэрэгт зарцуулагдана. Энэ нь өв залгамжлалын албан татварыг албан татварын нэг хэсэг үзэх үндэслэлийг бататгаж буй үзүүлэлт юм.

Нэг. Харилцааны хүрээгээр буюу өв залгамжлах эрхтэй этгээдийн төрөл садангийн хүрээг хумих

Өв залгамжлагчийн ойрын төрөл садангаас бусад төрөл, садныг хууль ёсны өв залгамжлагчаас халах, өөрчлөх санааг эдийн засгийн үзэл баримтлалын хувьд дэмжиж ирсэн байна. Тухайлбал, Бентам³,

² Max West “The theory of the inheritance tax”. Political Science Quarterly, Vol 8. №3 (Sep.,1893).,Oxford university press p.426 /last accessed 21 Aug 2025/

³ Jeremy Bentham /1748–1832/ Английн хуульч, философич, утилитаризмын үндэслэгч. Тэрээр нийгмийн ашигт нийцэхгүй аливаа тогтолцоог утгагүй гэж үздэг байсан тул ойрын бус холын хамаатнуудын өв залгамжлалыг зөвтгөх боломжгүй.

Анфантин⁴, Блунтшли⁵ нарын эрдэмтдийг нэрлэж болно. Энэ үзэл баримтлалаар холын хамаатнуудад өв хөрөнгөө шилжүүлэх явдлыг ашиг тусгүй зүйл хэмээн шүүмжилдэг. Орчин үед гэр бүлийн эв нэгдэл, ухамсар нь ихэвчлэн эцэг, эхийн үеэл ах дүүсийн хүрээнд хадгалагдаж байгаа тул түүнээс цааших хамаатнуудад өв залгамжлах эрх олгох хангалттай үндэслэл байхгүй гэж үздэг. Гэхдээ өв залгамжлалын эрхийг ямар түвшнээс бүр мөсөн зогсоохыг хууль тогтоомжоор тогтоох нь төвөгтэй асуудал юм. Иймд энэ арга замын шийдэл нь холын хамаатнуудын өв залгамжлах эрхийг бүрэн үгүйсгэх бус шаталсан өв залгамжлалын албан татвар тогтоох явдал гэж үздэг⁶. Энэ нь төрөл садангийн холбоо ойр, хол байхаас хамаарч татварын хувь хэмжээ өөр өөр тогтоогдох бөгөөд холын хамаатнуудын хувьд илүү өндөр татвар ногдуулах зарчимтай.

Дээрх зарчмыг Английн хуульч, философич Ж.Бентам санал болгосон ба түүний санал болгосноор нэгдүгээр үеийн өв залгамжлагчид татвараас чөлөөлөгдөх, хоёрдугаар үеийн өв залгамжлагчид өвлөн авсан эд хөрөнгийн тал хувийг татварт төлөх, харин гуравдугаар үеийн залгамжлагчаас дээш, нас барагч гэрээслэл үлдээгээгүй тохиолдолд хөрөнгийг бүхэлд нь төр авна гэжээ.

Хоёр. Хэмжээгээр буюу нэг этгээд өөр нэг этгээдийн хөрөнгөнөөс өвлөн авах дээд хэмжээг тогтоох

Өвлүүлэх эд хөрөнгийг ойрын болон холын төрөл садангийн байдлаар шаталсан татвараар хязгаарлаж болохоос гадна өвлөгдөх эд хөрөнгийн хувь хэмжээгээр хязгаарлаж болдог байна. Энэ арга зам нь прогрессив буюу өсөх хувьтай өв залгамжлалын албан татвар юм. Зарим тохиолдолд их хөрөнгийг үе дамжин хадгалахаас сэргийлэхийн тулд өв залгамжлал, гэрээслэлээр үлдээх хөрөнгийн дээд хязгаарыг тогтоох явдал юм. Энэ саналыг XIX зууны Английн нэрт эдийн засагч, философич **Жон Стюарт Милль** АНУ-ын Иллинойс мужийн хууль тогтоох байгууллагад тухайн мужийн өмгөөлөгчдийн холбооны тусгай хорооны саналын дагуу хуулийн төслийг өргөн барьсан байна. Тухайн төслөөр шууд өв залгамжлагчийн хөрөнгийг 500,000 ам.доллар, бусад тохиолдолд 100,000 ам.доллараар тус тус хязгаарлах санал гаргасан байна. Ийм төрлийн өв залгамжлалын хязгаарлалтыг хэд хэдэн удаа санал болгож буй явдал нь ирээдүйд хэрэгжих боломжтой байхыг үгүйсгэх аргагүй юм.

⁴ Barthélemy Prosper Enfantin /1796–1864/ - Францын социалист сэтгэгч, Сен-Симонист хөдөлгөөний удирдагч. Түүний хувьд өмчийн шударга хуваарилалт чухал тул өв залгамжлалын эрхийг ойрын хүрээгээр хязгаарлах ёстой гэж үзжээ.

⁵ Johann Caspar Bluntschli /1808–1881/ – Швейцарын хуульч, улс төр судлаач, олон улсын эрх зүйн нэрт онолч. Тэрээр төрийн үүргийг хүчтэй тодорхойлж байсан тул холын хамаатны өв залгамжлалыг төрд шилжүүлэх санааг дэмжсэн.

⁶ West, supra note 2, 427.

Дээрх тогтолцоог хэрэгжүүлэх боломжтой гэж үзвэл шаталсан өв залгамжлалын албан татвар хэлбэрээр хэрэгжвэл илүү үр дүнтэй. Учир нь тодорхой нэг хэмжээнд өв залгамжлал, гэрээслэл чөлөөтэй үйлчлэх боломжтой байснаа гэнэт бүрэн зогсохоос илүүтэйгээр хувь хэмжээг өсгөх байдлаар тогтоох нь зүйд нийцнэ. Өв залгамжлалын хэмжээг хязгаарлахын тулд заавал дээд хэмжээ тогтоож, түүнээс цааш төр авах байдлаар шийдэх албагүй. Үүний оронд шаталсан буюу прогрессив өв залгамжлалын албан татвар хэрэгжүүлэх боломжтой. Шаталсан буюу прогрессив өв залгамжлалын албан татвар нь их хэмжээний өв залгамжлалд өндөр татвар ногдуулах, бага хэмжээний өв залгамжлалд бага татвар ногдуулна. Энэ нь хөрөнгийг олон хүнд хуваах, дэмжих явдал тул баялгийн түгээлтийг өөр нэг замаар хангахад нөлөөлдөг.

Өв залгамжлалын хэмжээг хязгаарлах арга нь шаталсан татвар болон бага хэмжээний хөрөнгийг татвараас бүрэн чөлөөлөх явдал юм. Тухайлбал, их хэмжээний хөрөнгөд ногдуулах татвар бага хэмжээний хөрөнгөд ногдуулах хувь хэмжээтэй адил тохиолдолд хөрөнгийг хязгаарлах үүргээ биелүүлж чадахгүй. Өв залгамжлалын хэмжээг хязгаарлах асуудлыг авч үзэхдээ, өв залгамжлалын албан татварын шаталсан тогтолцоо нь ерөнхий татварын шатлалын асуудлаас өөр ойлголт бөгөөд өв залгамжлалд шаталсан татвар ногдуулахад хамгийн зохистой объект гэж үздэг. Учир нь өв залгамжлал тухайн хүн өөрөө бий болгосон орлого бус тохиолдлын байдлаар олдсон баялаг тул илүү өндөр татвар ногдуулах нь шударга, их хэмжээний хөрөнгө үе дамжин төвлөрөхийг сааруулснаар нийгэмд баялгийн түгээлт өргөжих, иргэдийн амьдралын үндсэн хэрэгцээг хангасан бага хэмжээний өв хөрөнгийг татвараас чөлөөлөх боломжтой тул нийгмийн эсэргүүцэл бага байдаг байна.

Мөн Английн нэрт эдийн засагч, философич Жон Стюарт Милль “Өв залгамжлал нь жирийн орлогоос ялгаатай бөгөөд өв хүлээн авагчийн өөрийн хөдөлмөр, бүтээмжийн үр дүн бус бусдын үлдээсэн баялаг тул татвар ногдуулахад хамгийн тохиромжтой зүйл”, “Өв залгамжлалын албан татвар өндөр байвал нас барахаас өмнө хөрөнгөө бусад этгээд рүү шилжүүлэх, эсхүл нуух зэргээр татвараас зайлсхийх арга хэрэглэх тул татварын хувь хэмжээг бодитоор тогтоох”, “бүх орлогод шаталсан татвар ногдуулах нь шударга бус, харин өв залгамжлал, гэрээслэлд шаталсан татвар ногдуулах нь зүй ёсны байх болно”⁷ гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, хүн өөрөө хөдөлмөрлөж олсон орлого, хөрөнгөд хязгаарлалт байх ёсгүй, харин өөрийн хөдөлмөрөөр бус олдсон хөрөнгө нийгмийн хяналт, хязгаарлалтад орох ёстой гэж

үзжээ.

⁷ Ibid 427.

Өв залгамжлалын хэмжээг хязгаарлах эсэх нь маргаантай асуудал. Тухайлбал, өмч хөрөнгийг хувь хүний бус гэр бүлийн өмч гэж үзвэл өв залгамжлалыг гэр бүлийн хүрээнд хязгааргүй олгох юм. Холбооны Бүгд найрамдах Герман улс, Австрийн эрх зүйд үйлчилдэг “заавал ногдох хувь” буюу нас барсан хүний гэрээслэлээс үл хамааран нөхөр, эхнэр, хүүхэд зэрэг ойрын төрлийн гэр бүлийн гишүүдэд заавал ногдох хууль ёсны хувь, өөр нэг зарчим нь “хууль ёсны эрх” буюу гэр бүлийн гишүүдийн хууль ёсоор баталгаажсан эрх, хувь хэмжээг гэрээслэлээр хасаж болохгүй гэсэн зарчим үйлчилдэг боловч ихэнхдээ өв залгамжлалын тогтолцоо нь гэр бүлийн гишүүдийн эрхийг баталгаажуулах гэхээс илүүтэйгээр нас барсан этгээдийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Сэр Хэнри Мэйний тодорхойлсноор Ромын эрх зүйд гэрээслэл нь анх өв залгамжлалын эрхийг хязгаарлахын тулд бий болоогүй, хууль ёсны гэр бүл болон цусан төрлийн холбоог тэнцвэржүүлэх зорилгоор хууль ёсны гэр бүлийн эрхийг хамгаалах, ойрын төрөл садан байхгүй үед өв залгамжлагч бий болгох зорилгоор нэвтэрчээ. Харин анхны зорилго нь үгүй болж, Англи-Саксоны эрх зүйд гэрээслэлийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн тул энэ нь олон нийтэд төрөлхийн эрх мэт ойлгогдож эхэлсэн байна.

Нью-Йорк хотын шүүхийн шүүгч Рэнсом “хүн эд хөрөнгөө гэрээслэх нь ёс суртахууны болоод хууль ёсны эрх, нас барахаас өмнө өмч хөрөнгөө худалдах, бэлэглэх эрхтэй адил ойлголт” гэжээ. Висконсин муж нь эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх байгаа бол хөрөнгийнхөө тал хувиас илүүг буян, шашин, шинжлэх ухаан, уран зохиол, боловсролын байгууллагад гэрээслэхийг хориглосон явдал нь гэрээслэх эрхэд хязгаарлалт тавих эхлэл болж байна. Энэ нь цаашид гэрээслэл бичиж буй этгээд үр хүүхдэдээ өмч хөрөнгөө үлдээхгүйгээр бусдад өвлүүлэх харилцааг хориглох явдал байж болох юм.

III. Хоёрдугаар хэсэг. Өв залгамжлалын албан татварын онолууд

Өв залгамжлал нь гэр бүлийн суурь харилцаа болох эцэг, эх нь үр хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой. Энэ нь гэр бүлийн хүрээнд өв залгамжлах эрх нь хязгааргүй байх ёстой гэсэн үг биш. Учир нь эцэг, эхийн үүрэг нь үр хүүхдээ тэжээн тэтгэх, суурь боловсрол олгох, амьдралын наад захын хэрэгцээгээ хангах боломжийг бүрдүүлэх явдал юм. Ёс суртахууны зарчмын хувьд хөрөнгө чинээлэг эцэг, эх хүүхдүүдээ заавал чинээлэг болгох ёстой гэж шаардахгүй, их хэмжээний хөрөнгө өвлүүлэх нь түүнийг урамшуулах бус өв залгамжлагчид төдийгүй нийгэмд асар их хохирол учруулах эрсдэлтэй. Энэ нь Монтескьегийн

“Байгалийн хууль эцгүүдийг хүүхдүүдээ тэжээхийг шаарддаг боловч тэднийг өв залгамжлагч болгохыг шаарддаггүй” гэсэнтэй нийцэж байна. Мөн үр хүүхдээ амьдралд бэлдэх үүрэг бол ёс суртахууны зайлшгүй шаардлага, харин **хөрөнгө өвлүүлэх нь ёс суртахууны зайлшгүй шаардлага биш** гэдгийг харуулж байна.

Өв залгамжлалын албан татварыг зөвтгөх өөр нэг үндэслэл нь баялгийг олон хүнд тарааж, нийгэмд тэгш хүртээмж бий болгох явдал юм. Энэ үндэслэл нь бусад үндэслэлтэй харьцуулахад социалист хандлагатай төстэй. Жишээ дурдахад, АНУ-д XIX зууны сүүл үеэр **Андрю Карнеги** их хэмжээний хөрөнгийн төвлөрлийг бууруулахын тулд 50 хувь хүртэлх өв залгамжлалын албан татварыг дэмжиж байсан байна. Энэ үндэслэлийг АНУ-ын улс төр-нийгмийн сэтгэгч Эдвард Беллами хөгжүүлж, өв залгамжлалын албан татварыг шатлан тогтоохыг дэмжиж, өв хөрөнгөө үлдээхдээ төрөл садны ойр, хол байдлаар ялгаварлахыг дэмжээгүй байна. Мөн өв залгамжлалын албан татвар нь эдийн засгийн тэгш байдлыг бий болгох хэрэгсэл⁸ гэж үзсэн байна. Гэхдээ өв залгамжлалыг татвараар хязгаарлах нь социалист хандлага, хувийн өмчид халдсан гэж үзэх нь учир дутагдалтай. Учир нь өв залгамжлах эрхийг жам ёсны эрх гэж үзэх бус өвлүүлэгч этгээд өмч хөрөнгөө амьд байхдаа захиран зарцуулах эрх нь түүнийг нас барсны дараа хэн захиран зарцуулах эрхийг заана гэсэн үг биш. Өв залгамжлалын эрхийг өргөн хүрээнд олгох бол ямар тохиолдолд олгох, түүний хувь хэмжээг хэрхэн хязгаарлахыг нийгмийн зайлшгүй шаардлагын үндсэн дээр шийдэх ёстой⁹.

А. Ашиг хүртэх онол /Benefits theory of taxation/

Энэ онолд тулгуурлан өв залгамжлалын албан татварын төрөөс үзүүлж буй олон төрлийн үйлчилгээнд төлж буй хариу төлбөр гэж тайлбарлаж иржээ. Өөрөөр хэлбэл, иргэд төрийн үйлчилгээнээс хэр их ашиг хүртэж байна, түүнийхээ хэмжээгээр татвар төлнө гэсэн үг. Эдийн засагч Эшенбахын зураглалаар өв залгамжлалын харилцаанд төр, иргэн хоёрыг “чимээгүй түнш” гэж тодорхойлсон ба иргэн баялаг бүтээхдээ төрийн хууль, хамгаалалт, нийгмийн тогтвортой байдлыг ашигладаг тул хүн нас барахад энэ түншлэл дуусаж төр (түншийн хувьд) үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх нь зүй ёсны хэрэг гэж тайлбарлажээ¹⁰. Дэлгэрүүлж тайлбарлавал, өвлүүлэгчийн холын төрөл садан гэх хүмүүс тухайн хөрөнгийг бий болгоход оролцоогүй, харин төрийн оролцоо бол зайлшгүй байгаа тул төрийн шаардлага илүү үндэслэлтэй гэжээ.

Энэ үндэслэл нь төр, иргэн хоёрын хоорондох харилцаа, төрийн

⁸ West, supra note 2, 430.

⁹ West, supra note 2, 431.

¹⁰ Мөн тэнд

хэрэгжүүлдэг олон талын ашигтай үүргүүдийн онцолж төр нас барсан этгээдийн хөрөнгөнөөс хувь хүртэх шаардлагыг бий болгодог.

В. Өв залгамжлалын албан татвар төрийн үйлчилгээнд зориулагдах нь

Нас барсан этгээдийн өмчийг түүний өв залгамжлагч нарт хуваарилж, тэдгээр этгээдийг тодорхойлж, өв хүлээн авагч өмчлөлдөө авахад шаардлагатай ажиллагаа, тухайн хугацаанд өмч хөрөнгө хууль бус халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх үед төрөөс өмчийг хамгаалах үйл ажиллагааг хариуцдаг тул төрийн үйлчилгээний төлбөрт төлбөр төлөх ёстой гэж үздэг. Энэ үзэл баримтлалыг Францын нэрт эдийн засагч Паул Леруа Беаулиэ өв залгамжлах эрхийг хууль зүйн зохиомол эрх буюу хүн нас барсныхаа дараа өмчөө бусдад шилжүүлэх эрх нь байгалийн биш, харин хууль тогтоомжоор олгогдсон эрх¹¹ гэж үзжээ. Хууль, шүүхийн ажиллагаа, өмчийн бүртгэл, хамгаалалт байхгүй үед өв хөрөнгө дамжих боломжгүй тул өв залгамжлагчид төрөөс тусгай үйлчилгээ авч байдаг санааг дэвшүүлсэн байна. Тэрээр уг санаагаа даатгалын хураамжтай адилтган зүйрлэж, даатгалын хураамж нь өмчийг хамгаалж, аливаа эрсдэлийг багасгах төлбөр байдаг бол өв залгамжлалын албан татвар нь төрийн үйлчилгээ үзүүлсэн төлбөр¹² гэж үздэг байна.

Энэ онолоор өв залгамжлалын албан татварыг холын ба ойрын төрөл садангаар шатлан тогтоохыг зөвтгөж, өв залгамжлалын харилцааг зохицуулсан хууль байхгүй байсан бол өв хөрөнгө эцгээс хүүд байгалийн жамаар шилжинэ. Харин холын төрөл садан эсхүл цусан холбоогүй этгээд төрийн үйлчилгээний ачаар өв залгамжлах эрхийг олж авдаг гэжээ. Мөн өв залгамжлалын хэмжээг тодорхойлоогүй боловч холын төрөл садангийн хувьд өв хөрөнгө залгамжлахдаа төрөөс хамаарах тул хөрөнгөний ихэнх хэсгийг татвар болгон авах үндэслэлтэй гэжээ.

С. Үйлчилгээний өртгийн онол

Энэ онол нь төрийн үйлчилгээ иргэн бүрд хэр үнэ цэнтэй вэ гэдгийг бус, харин төрөөс гарч буй зардлын хэмжээгээр тайлбарладаг байна. Төрийн үйлчилгээгээр дамжин өв хөрөнгийг өмчлөгчөөс өв залгамжлагчид шилжүүлэх ажиллагаанаас хамгийн их ашиг хүртэж буй этгээдүүд нь өв залгамжлагч тул уг зардлыг төлөх нь шударга хэрэг юм. Судлаачид энэ онолд төдийлөн анхаараагүй боловч АНУ-ын зарим муж улсуудын хууль тогтоомжид нөлөөлсөн гэж үздэг. Тухайлбал, Нью Хэмпшир, Миннесота, Висконсин, Иллинойс зэрэг мужид өв залгамжлалын албан татварыг төрийн зардлыг нөхөх

¹¹ Paul Leroy-Beaulieu, *Traité de la science des finances*, (Paris:1877).

¹² Paul Leroy-Beaulieu, *L'État moderne et ses fonctions*, (Paris:1890).

зорилгоор бага хувьтайгаар тогтоож байжээ¹³.

Үйлчилгээний өртөгт суурилсан татвар нь буурах шинжтэй буюу хөрөнгийн хэмжээ их хэрээр бага дарамт үзүүлэх, эсхүл бүх хөрөнгөд ижил хувь ногдуулах, татвар нь өндөр бус, төрөл садны зэргээс хамааран ялгаварлах ёсгүй. Дээр дурдсан муж улсуудын өв залгамжлалын албан татвар нь 1 хувиас хэтрэхгүй, бага байсан байна. Висконсин мужийн хувьд өв залгамжлах өмч хөрөнгийн хэмжээ ихсэх тусам татварын хувь хэмжээ буурах зарчмын дагуу бага тогтоодог байна.

Гэхдээ өв залгамжлалын албан татвар нь төрийн үйлчилгээний төлбөр бус өмчтэй этгээдүүд амьд ахуйдаа төлөхөөс зайлсхийсэн татварын нөхөн төлбөр гэж үзэх нь бий. Энэ үүднээс татварыг төрөл садангийн зэргээс шатлан тогтоох нь үндэслэлгүй, учир нь татварыг өв залгамжлагч бус харин өвлүүлэгчийн нөхөн төлбөр гэж тооцно гэжээ. Их хэмжээний хөрөнгөтэй этгээдүүд татвараас зайлсхийх боломж нь бага хөрөнгөтэй этгээдүүдээс илүү байдаг тул өв залгамжлалын шаталсан татвар нь хөрөнгөний ялгаатай этгээдүүдийн хооронд тодорхой хэмжээгээр шударга ёсыг хангахад чиглэдэг байна.

Өв залгамжлалын албан татварыг өөр нэг аргаар тайлбарлах үндэслэл нь энэ татвар өмнө нь төлөхөөс зайлсхийсэн татварын нөхөн төлбөр бус анхнаасаа ногдуулаагүй татварын нэг хэсэг гэж үзэх явдал юм. Өөрөөр хэлбэл, жил бүрийн орлогын албан татварыг нэг үе тутамд нэг дор төлж буй “капиталжсан орлогын татвар”¹⁴ гэж үзжээ. Энэ татвар нь өвлүүлэгчийг нас барсны дараа төлөгдөх тул хамгийн тохиромжтой цаг үед татвараа төлж байна гэж ойлгодог. Нөгөө талаар өв залгамжлагчийг татвараа урьдчилан төлсөн гэж үздэг. Өв залгамжлалын албан татвар бий болсноор жил бүрийн татварын дарамтыг хөнгөлөх тул нэмэлт татвар бус өмчийн, орлогын татварын тодорхой хэсгийг онцгой аргаар ногдуулах хэлбэр юм.

D. Санамсаргүй орлого

Энэ онол ёсоор өв залгамжлал, гэрээслэлээр олж буй хөрөнгө гэнэтийн шинж чанарт тулгуурладаг. Энэ нь өв хүлээн авагчийн хөдөлмөрөөс ангид, гэнэтийн байдлаар бий болсон, өвлөгчийн татвар төлөх чадварыг илт нэмэгдүүлдэг. Орлогын татвар үйлчилдэг нөхцөлд өвийг орлого гэж тодорхойлж болох боловч санамсаргүй, гэнэтийн байдлаар олдсон шинж чанараас нь үүдэн орлогын татвараас илүү өндөр хувьтай, эсхүл орлогын татвар дээр нэмэлтээр онцгой татвар ногдуулах нь шударга гэж үзэх нь бий. Гэхдээ өмч хөрөнгө өвлөж буй этгээдийн татвар төлөх чадвар нэмэгдсэн гэж үзэхгүй. Тухайлбал,

¹³ West, *supra* note 2, 432.

¹⁴ West, *supra* note 2, 433.

Адам Смитийн тэмдэглэсэнээр гэр бүлийн өрхийн тэргүүн нас барсан тохиолдолд эхнэр, хүүхдүүдэд эдийн засгийн бодит хохирол учирна. Харин гэр бүлийн орлого нь гэр бүлийн хөрөнгөнөөс бий болж байгаа бол нас барсан этгээд гэр бүлийн орлогод сөргөөр нөлөөлөхгүй. Гэр бүлийн орлого хүүхдүүдээс шалтгаалж байсан бол гэр бүлийн орлогын байдал сайжирч, нас барсан этгээдэд зарцуулагдаж байсан зарлага буурна. Оршуулгатай холбоотой зардлыг даатгал, оршуулгын тэтгэмжээр нөхөх боломжтой. Өвлүүлсэн хөрөнгө холын төрөл саданд эсхүл нас бие хүрсэн этгээдэд шилжсэн тохиолдолд татвар төлөх чадвар тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Мөн өвлүүлэгчийн хамаарал бүхий этгээдээс холдох тусам өвлүүлсэн хөрөнгө “санамсаргүй орлого”-д тооцогдоно.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан өв залгамжлалын албан татварыг төрөл садангийн хол, ойр зэргээр шатлан тогтоох нь зүй ёсны хэрэг бөгөөд бэлэвсэн эхнэр, насанд хүрээгүй хүүхдүүдийг татвараас бүрэн чөлөөлөх, эсхүл татварын зарим хэсгээс чөлөөлж, бага татвар ногдуулдаг байна. Санамсаргүй орлогын онол нь шаталсан татвар ногдуулах үндэслэлийг зөвтгөнө. Учир нь тухайн этгээдийн өвлөн авсан хөрөнгийн хэмжээ ихсэхийн хэрээр нэгж хөрөнгийн бодит үнэ цэнэ, хэрэгцээг хангах ач холбогдол нь багасдаг. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний өв хөрөнгө авсан этгээдэд тухайн хөрөнгө амьдралын нөхцөлийг мэдэгдэхүйц сайжруулах нөлөөтэй байхад их хэмжээний хөрөнгө авсан этгээдийн хувьд нэгж хөрөнгийн ашигт чанар үлэмж буурдаг. Иймээс өв залгамжлалын албан татварыг шаталсан байдлаар ногдуулах нь эдийн засгийн хувьд зөвтгөгдөх боломжтой бөгөөд татварын шударга байдлыг хангах чухал үндэслэл болдог гэж үздэг.

Е. Төр хамтран өвлөгч байх /theory of state co-heirship/¹⁵

Швейцарь улсын хуульч, улс төр судлаач олон улсын эрх зүйн онолч Иоганн Каспар Блунтшли¹⁶ төрөл садангийн зэргээс шалтгаалан шаталсан системээр өв залгамжлалын албан татвар ногдуулах, төрсөн эцэг, эхээс гараагүй бусад этгээдийн хоорондох өв залгамжлал, гэрээслэлийг хориглохыг санал болгож, төр, өвлүүлэгч хоёрыг хамтран өвлөгч гэж үзсэн. Энэ ойлголтыг Герман эрдэмтэд болон АНУ-ын эдийн засагч, профессор Ричард Т.Эли¹⁷ дэмжиж хэрэглэсэн

¹⁵ “A review devoted to the historical statistical and comparative study of politics economics and public law”, Political Science Quarterly, Vol. 8, (1883), 436, https://www.google.mn/books/edition/Political_Science_Quarterly/FNAKLodZyGkC?hl=en&gbpv=1&dq=theory+of+state+co-heirship&pg=PA436&printsec=frontcover

¹⁶ Өв залгамжлал, гэрээслэл нь жам ёсны эрх биш, харин төрөөс зөвшөөрч тогтоосон эрх зүйн ойлголт юм. Энэ үүднээс хүн нас барахад үлдээсэн хөрөнгийг өв залгамжлагчид авахын зэрэгцээ төр тодорхой хэмжээгээр хамтран өвлөгч байх ёстой.

¹⁷ Өв залгамжлал, гэрээслэл нь байгалийн эрх биш бөгөөд харин төрөөс тогтоосон

бөгөөд төр хамтран өвлөгч гэх нэр томъёог өв залгамжлалыг хязгаалах онолд ашигласан байна. Германы эрх зүй, санхүү судлаач Крюгер Ж.Бентамыг уг онолын гол төлөөлөгчөөр нэрлэж, түүний санаа нь зөвхөн ойрын төрөл саданд хооронд өв залгамжлалыг хүлээн зөвшөөрөх, ойрын өвлөгч үгүй тохиолдолд гэрээслэлийн эрхийг хязгаарлах, хөрөнгийн тодорхой хэсгийг улсад шилжүүлэх явдал¹⁸ гэжээ. Үүний дараагийн үеийн төлөөлөгчид түүний үндэслэлийг төрийг “чимээгүй түнш” гэх үзэлтэй нэгтгэн, өв залгамжлах процесст төр оролцдог тул хөрөнгийг өвлөн авах ёстой гэж үзсэн.

IV. Дүгнэлт

Монгол Улсын татвар нь хэд хэдэн төрлөөс бүрдэх бөгөөд үүний нэг нь өв залгамжлалын албан татвар юм. Тодруулбал, төсөв татварын орлогоос бүрдэхийн хувьд өв залгамжлалын албан татвар нь төсөв бүрдүүлэх нэг хэрэгсэл болох ба ердийн хуулиар өв залгамжлалын албан татварыг хүлээн зөвшөөрсөн байна. Энэхүү өгүүллээр өв залгамжлалын албан татварын эрх зүйн онолын үзэл баримтлалын талаар судалсан болно.

Өв залгамжлалын албан татвар нь зөвхөн төрийн орлого бүрдүүлэх арга хэрэгсэл төдийгүй, нийгэм дэх баялгийн хэт төвлөрлийг хязгаарлаж, эдийн засгийн шударга байдлыг хангах чухал үүрэгтэй болохыг Макс Уэст 1893 онд бичиж байсан байна. Тэрээр өв залгамжлал, бэлэглэл нь байгалийн зайлшгүй эрх бус нийгэм, төрийн хуулиар зөвшөөрөгдсөн харилцаа тул төр нь уг эрхийн хүрээг татвар, хязгаарлалтаар зохицуулах үндэслэлтэй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, өв залгамжлах эрх нь хүний жам ёсны эрх биш бөгөөд хүний бүтээсэн нийгэм тул түүнд татвар ногдуулах нь зөв гэж үздэг байна.

Анх Ромын эрх зүйд өв залгамжлал нь хууль ёсны гэр бүл болон цусан төрлийн холбоог тэнцвэржүүлэх зорилгоор гэр бүлийн эрхийг хамгаалах, ойрын төрөл садан байхгүй үед өв залгамжлагч бий болгох зорилгоор нэвтэрч байсан бол хөгжлийнхөө шатанд анхны зорилго өөрчлөгдөж, өв залгамжлалын гэрээслэлийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн тул энэ нь олон нийтэд жам ёсны эрх мэт ойлгогдож эхэлсэн байна. Өв залгамжлалыг харилцааны хүрээгээр буюу өв

хууль, эрх зүйн ойлголт. Иймээс төрийг өв залгамжлалын хамтран өвлөгч гэж үзэж, өв залгамжлуулж буй хөрөнгийн тодорхой хэсгийг авах эрхтэй гэж үзсэн. Энэ нь нийгэмд шударга ёсыг тогтоох, баялгийн хэт төвлөрлийг сааруулах ач холбогдолтой. Richard T. Ely, *Taxation in American States and Cities*, (New York: 1888).

¹⁸ *Studies in history economics and public law*, The university faculty of political science of Columbia college., Volume fourth. New York., (1893-1894.), P.119 https://www.google.mn/books/edition/The_Inheritance_Tax/cQd7-INN5IYC?hl=en&gbpv=1&dq=theory+of+state+co-heirship&pg=RA1-PA118&printsec=frontcover

залгамжлах эрхтэй этгээдийн төрөл садангийн хүрээгээр болон хэмжээгээр буюу нэг этгээд өөр нэг этгээдийн хөрөнгөөс өвлөн авах дээд хэмжээг тогтоох замаар хязгаарладаг байна. Энэ нь дээр дурдсан өв залгамжлал хүний жам ёсны эрх бус хүний бүтээсэн нийгэм гэж үздэгтэй холбоотой.

Өв залгамжлалын харилцаанд төр нь өвлүүлэх эд хөрөнгийг хамгаалах, шилжүүлэх, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зэргээр оролцдог тул төр өв залгамжлах хөрөнгөнөөс ашиг хүртэх ёстой гэж үздэг байна. Учир нь иргэд төрийн үйлчилгээнээс хэр их ашиг хүртэж байна, түүнийхээ хэмжээгээр татвар төлөх ба энэ харилцааг чимээгүй түнш ч гэж тодорхойлдог байна. Мөн өвлүүлэгчийн хөрөнгийг өв залгамжлагч нарт хуваарилж, тэдгээр этгээдийг тодорхойлж, өв хүлээн авагч өмчлөлдөө авахад шаардлагатай ажиллагаа, тухайн хугацаанд өмч хөрөнгө хууль бус халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх үед төрөөс өмчийг хамгаалах үйл ажиллагааг хариуцдаг тул төрийн үйлчилгээний төлбөрт төлбөр төлөх ёстой гэжээ.

Өв хүлээн авагчийн зэрэглэлээс хамаарч өвлүүлсэн хөрөнгө нь зарим этгээдэд гэнэтийн орлого болж, орлогыг ихээхэн нэмэгдүүлдэг. Тодруулбал, өв хөрөнгийг холын хамаатан садан эсхүл гэрээслэлээр цусан төрлийн холбоогүй этгээдэд өвлүүлэх нь тухайн этгээдэд санамсаргүй орлого болдог тул түүнд тохирсон татвар төлөх үүрэгтэй. Иймд өв залгамжлалын албан татвар байх ёстой гэдгийг хэд хэдэн онолоор бататгасан ба харин татварын хувь хэмжээний талаар тусад нь авч үзэх нь зүйтэй.

[Ном зүй]

Ганхүлэг Б., Татварын тогтолцоо (Тэргүүн дэвтэр), Улаанбаатар: 2002 он.
Мишигдорж М., Лхагвасүрэн Д., Хишигбаяр Л., “Өв залгамжлал болон бэлэглэлийн татварын үүсэл, олон улсын туршлага”, *Journal of Accounting Theory and Practice*, Vol. 5, No. 2, 2021 он.

Сарнай Б., “ХБНГУ болон Австри улсын хууль ёсны өв залгамжлалын зарим асуудал”, Монголын шүүх, эрх зүй судлал, №1 (111), 2025 он.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1, 1992 он.

Татварын ерөнхий хууль (Шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2008 он, №22, 2008 он.

Татварын ерөнхий хууль (Шинэчилсэн найруулга), Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №22, 2019 он.

Ely Richard T., “The Inheritance of Property”, *The North American Review*, Vol. 153, No. 416, 1891.

Leroy-Beaulieu Paul, *L'État moderne et ses fonctions*, 1890.

Leroy-Beaulieu Paul, *Traité de la science des finances*, 1877.

West Max, “The Theory of the Inheritance Tax”, *Political Science Quarterly*, Vol. 8, No. 3, 1893.

“A review devoted to the historical statistical and comparative study of politics economics and public law”, *Political Science Quarterly*, Vol. 8, 1883.

“Studies in history economics and public law”, *The university faculty of political science of Columbia college*, Vol. 4, 1893-1894.

[Abstract]

Some Theoretical Issues in Inheritance Tax Law

Sarnai Bayar-Erdene

Master of Laws (LL.M.).

Ulaanbaatar, Mongolia

A citizen's guaranteed rights and freedoms include the right to justly acquire, possess, own, and inherit movable and immovable property. Within the scope of fundamental rights, when a citizen transfers to heirs the property they have created, an economic relationship arises between the heir and the testator; therefore it is argued that, within the framework of their basic duties, they should be liable to taxation.

Although inheritance tax is regulated as a type of tax, it is not implemented in practice and has become largely symbolic. Accordingly, this study seeks to examine inheritance tax from the standpoint of economic science and to answer whether an inheritance tax should exist; the research is limited to the theory of inheritance taxation.

[Keywords]

Inheritance, Economy, Inheritance Recipient, Heir, Fundamental Rights, Will, Tax.